



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/319

Улаанбаатар хот

Япон Улсад багш, судлаачдыг  
суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/308 дугаар тушаалаар батлагдсан “Япон Улсад инженер, технологийн чиглэлээр коосэн, хамтарсан бакалавр, магистр, доктор, зэргийн бус сургалтын хөтөлбөрт оюутан суралцуулах журам”-ын 2.7, 2.9 дэх заалт, төслийн удирдах хорооны 2015 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 16 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн шугамаар 2015-2016 оны хичээлийн жилээс Япон Улсын их сургуулиудын магистр, доктор сургалтын хөтөлбөрт суралцуулах багш, судлаачдын нэрсийг хавсралт ёсоор баталсугай.

2. Япон Улсад суралцах багш, судлаачидтай журмын дагуу сургалтын зээлийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, Монгол улсын их сургууль /Р.Бат-эрдэнэ/, Шинжлэх ухаан, технологийн их сургууль /Б.Очирбат/ нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Насанбаяр/, Санхүү, эдийн засгийн газар /Ц.Баярхүү/, Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус үүрэг болгосугай.



Л.ГАНТӨМӨР

Боловсрол, соёл, шинжлэх ухааны  
сайдын 2015 оны 8 дугаар  
сарын 17-ны өдрийн 13/3 дугаар  
тушаалын хавсралт

ЯПОН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОР СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ 2015-2016 ОНЫ  
ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС СУРАЛЦАХ БАГШ, СУДЛААЧДЫН НЭРС

Д/д	Эцэг, (эх)-ийн нэр, нэр	Ажиллаж буй сургууль	Япон Улсад суралцах сургууль	Суралцах хугацаа	Судалгааны чиглэл	Хамрагдах хөтөлбөр
1.	Мягмардулам Билгүүнмаа	ШУТИС	Нагаокагын Технологийн их сургууль	2 жил	Зайн тандан судлал Нисгэгчгүй онгоц төсөл	Магистр
2.	Батхуяг Энх-Учрал	МУИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан	Миязакигийн их сургууль	6 сар	Хатуу хог хаягдал боловсруулах менежмент	Судлаач оюутан
3.	Түмэнжаргал Төртогтох	МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль сургалтын инженер	Кюүшүгийн технологийн институт	3 жил	Лунукс үйлдлийн систем бүхий ARM процессор дээр суурилсан тусгай зориулалтын компьютер бүтээх	Доктор

-----oOo-----